

**Анхдугаар Үндсэн хууль (1924)-ийн
агуулгыг эрх зүйн үүднээс шинжлэх нь**

**Examination of Mongolia's first
Constitution (1924) from a legal perspective**


Данзангийн Лүндээжанцан

*Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D.), профессор
Шихихутуг их сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга
Улаанбаатар, Монгол Улс
lundeejantsan@gmail.com*

Цэдэндамбын Батбаяр

*Академич, Түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D.).
Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн
хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
Улаанбаатар, Монгол Улс
tsedendamba.bud@gmail.com*

© D.Lundeejantsan, Ts.Batbayar, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Их засаг хууль нь Монголын төр, улсын Үндсэн хуулийн эх сурвалж болох тухай. Үндсэн хуулийн тухай эрх зүйн ойлголт, ач холбогдол. Анхдугаар Үндсэн хуулийг боловсруулж баталгаажуулсан нь Монгол Улсын хөгжлийн түүхэн зайлшгүй үйл явдал болох тухай. Анхдугаар Үндсэн хуульд Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг баталгаажуулсан нь. Улс орны эдийн засаг, улс төр, нийгмийн болон хүний эрх, эрх чөлөөг тодорхойлсон Анхдугаар Үндсэн хууль, 1992 оны ардчилсан Үндсэн хуулийн заалтуудын эрх зүйн зарим харьцуулалт. Улс орны аюулгүй байдлыг хангах, баглан хамгаалах тухай, төрийн бэлгэ тэмдгийн тухай Үндсэн хуулийн заалтууд, тэдгээрийн ач холбогдол.

[Түлхүүр үг]

Үндсэн хууль, тусгаар тогтнол, эдийн засаг, улс төр, нийгэмшлийн үндэс, төрийн байгуулал, иргэдийн эрх, эрх чөлөө, сонгуулийн эрх.

I. Оршил

Монголын төрт ёс, эрх зүйн хөгжлийн түүхэнд “Их Засаг” хэмээх их хуулиар ертөнцийн дэг журмыг тогтоож, нэг мөр ойлгон, даган мөрдөж байсан тэр түүхэн цагаас олон зууны дараа Анхдугаар Үндсэн хууль Монголын ард түмний нийтлэг хүсэл зоригийг илэрхийлж, улс орныхоо тусгаар тогтносон бүрэн эрх, төрийн байгуулал, иргэд (жинхэнэ ард)-ийн эрх, эрх чөлөө, нутгийн захиргаа зэрэг нийгмийн суурь харилцаануудыг зохицуулсан хууль зүйн хувьд хамгийн дээд хүчин чадалтай гол хууль нь болжээ. Ингэснээр улс орны нийгэм улс төр, эдийн засаг, соёлын амьдралыг зохицуулах бусад бүх хууль тогтоомжийн үндэс, эрх зүйн үндэс эх сурвалж нь болсон байна.

Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаан нь Үндсэн хуулийн эрх зүйн институт (Улсын бүрэн эрхт байдал, төрийн хэлбэр, төрийн дэглэм, хүний эрх, төрийн байгууллагын тогтолцоо г.м) бүрийн үндсэн шинж, тэдгээрийн хоорондын холбоо, түүхэн уламжлал, хөгжлийн хандлагыг судалдаг.

II. Үндсэн хэсэг

БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хууль бол Үндсэн хуульд ёсны түүхэн эх сурвалж, Монгол Улсын Үндсэн хуулийн хөгжлийн бүрэлдэхүүн хэсэг учраас Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны үүднээс задлан шинжилж, авч үзэх нь зүй ёсны юм. Үндсэн хуулийн ач холбогдлыг товчоор хэлбэл, Монгол Улс ХХ зууны эхний 24 жилд хоёр удаагийн хувьсгалаар тусгаар тогтнолоо сэргээн, бэхжүүлэн хамгаалахад чиглэсэн нөр их ажил хийж, хичээн зүтгэсэн ч геополитикийн хайчинд орж нэн төвөгтэй нөхцөл байдлын дунд хүн ам цөөн, буурай хөгжилтэйн эрхээр хүчин мөхөсдөхийн зовлон зүдгүүрийг туулжээ. Энэ амаргүй үед Монголын тухайн үеийн эрх баригчид дотроо санал зөрөлдөөнтэй байсан хэдий ч Зөвлөлт Оросын нөлөөгөөр хөгжлийн чиг баримжааг сонгож, Үндсэн хуулийн төслийг маш богино хугацаанд боловсруулж, шатлан сонгогдож ирсэн ард түмний төлөөллийн дээд байгууллага Улсын их хурлаар батлуулсан нь түүхэн зайлшгүй зүйл байв. Тухайн цаг үеийн Монголын нийгмийн сонголт өнөө үеийнхээр бол жам ёсны хөгжлийг сонгож авах боломж туйлын хомс байсан, гадны дарамт шахалтын улмаас үнэндээ өөр сонголт байгаагүй гэж хэлж болно.

Монголын үндэсний ардчилсан үзэлтнүүдийн зүтгэлээр нийгмийн жам ёсны голдирлоор улс орныг удирдах, хууль тогтоох үйл ажиллагаа үндсэндээ 1928 оныг хүртэл үргэлжилж чадсан байдгийг энэ зурвас үеийн хууль тогтоомжид хийсэн судалгаа

харуулдаг. Энэ ч учраас “Анхдугаар Үндсэн хуулийг социалист болон үндэсний ардчилсан үзлийн зааг дээр батлагдсан гэж үзэх нь ч бий”. Үндсэн хуульт байгуулалд шилжсэн дэлхийн улс орнуудын эхний 30-д, Азийн орнуудаас эхний 3-т орж Монгол Улс Анхдугаар Үндсэн хуулиа баталсан билээ. Тухайн цаг үед дэлхий дахин болон ялангуяа Ази тивд ардчилал, хүний эрхийн асуудал, Үндсэн хуульт ёсны ухамсар, сэтгэлгээ ямар түвшинд байсан, Монгол Улсын төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхийн байдал төлөв, гадны нөлөө, дарамт шахалт (тухайлбал, Коминтерны) зэрэг гадаад, дотоод хүчин зүйлийг нарийн тунгааж үзвээс эдгээр нь цаг үеэ олсон (олохоос аргагүй) зоримог зүйл, төрийн том шинэтгэл байв.

Анхдугаар Үндсэн хууль нь нийт 6 бүлэг, 50 зүйлтэй

Нэгдүгээр бүлэг. Жинхэнэ ардын эрх чөлөөг илтгэн тунхаглах нь

Хоёрдугаар бүлэг. Улсын дээд эрхийг барих газрын тухай

Улсын их хурлын тухай

Улсын бага хурлын тухай

Улсын бага хурлын тэргүүлэгчдийн тухай

Засгийн газрын тухай

Гуравдугаар бүлэг. Нутгийн захиргааны тухай

Дөрөвдүгээр бүлэг. Сонгох, сонгогдох эрхийн тухай

Тавдугаар бүлэг. Улсын орлого, зарлагын эрхийн тухай

Зургаадугаар бүлэг. Улсын тамга ба сүлд тэмдэг, туг далбаа гурвын тухай

“Монгол Улсынхаа тусгаар тогтнолыг Үндсэн хуулийн хэмжээнд тунхагласнаар **улс төр, эдийн засгийн бүрэн тусгаар байдлын төлөө тэмцэх хууль зүйн үндсийг тавьсан**, ... хамжлага эзэмшлийн харилцааг **үндсээр нь халж хамжлага, шавь, ардыг эзний хараатаас улсын иргэн болгож**, хүн амын олонх болох жинхэнэ ардын (иргэдийн) эрх, үүрэг гэдэг цоо шинэ институт бий болгосон (Гэхдээ энэ нь “хүний эрх” гэсэн үг биш), төрийн захиргааны хаант хэлбэрийг халж, илүү дэвшилтэй Бүгд найрамдах ёсыг тогтоон, Монголын төрийн байгууллагуудын (Их, Бага хурал, түүний Тэргүүлэгчдийн, Засгийн газар, яамд гэсэн) шинэ тогтолцоог бэхжүүлсэн, Төрийн байгууламжийн нэгдмэл хэлбэрийг тогтоож, нутгийн захиргааны 5 шатат тогтолцооны (арван гэр, баг, сум, хошуу аймгийн) үндсийг бэхжүүлсэн, Улсын эдийн засгийн суурь, улсын төсвийн орлого, зарлагын тогтолцоог тодорхойлсноороо төрийн эдийн засаг, санхүүгийн үндсийг анхлан тогтоосон зэргийг дурдаж болно.

Хууль зүйн хувьд БНМАУ-д эх газрын хуультай төстэй,

Зөвлөлтийн нөлөөтэй эрх зүйн шинэ тогтолцоо бүрдэх суурь нь болж өгсөн зэрэгт түүний гол ач холбогдол оршино¹.

Анхдугаар Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд бүх хэргийг ард түмнээс удирдан гүйцэтгэх явдлыг хүндэтгэх гэсэн заалт нь засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх, төрийн эрх мэдлийн уг сурвалж ард иргэд байх зарчмыг анх удаа Үндсэн хуульд суулгаж өгсөн хэрэг бөгөөд энэ нь дараа дараагийн Үндсэн хуулиар бэхжигдэж, улмаар шинэ Үндсэн хуулийн мөн л 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болж (Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ) оржээ. Дээр дурдсан иргэдийн эрх, эрх чөлөө, үүргийг Анхдугаар Үндсэн хуульд тунхаглан заасны дотор эмэгтэйчүүдийн нэгэн адил тэгш эрх олгосон нь эмэгтэйчүүдийн эрхийг ардчиллын өлгийд тооцогддог орнуудаас хорь, гучин жилийн өмнө Үндсэн хуульдаа бэхжүүлж өгсөн хэрэг болов.

Анхдугаар Үндсэн хуульд “ардын хувьсгалт цэргийг бэхжүүлж, ард иргэдийг цэргийн эрдэмд сургахаар заасан нь тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх их хэргийн баттай үндэс” болсон байна. Ийнхүү Монголын төрт ёсны түүхэнд Монгол Улс анх удаа орчин үеийн бичмэл Үндсэн хуулийн хэлбэр, бүтэц, агуулгыг хангасан Үндсэн хуультай болсон нь эрх зүйн хөгжилд том дэвшил авчирчээ. Энэ ч чанараараа өнөөгийн шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэж батлахад хэлбэрийн төдийгүй агуулга, мөн чанарын талаасаа ч арга зүйн үндэс суурь болсонд түүний бас нэг түүхэн ач холбогдол оршино.

Анхдугаар Үндсэн хуулийн зорилго, зорилт, иргэдийн сонгох, сонгогдох эрх зэрэг асуудлаар ангич үзлийн үүднээс хандсан гэх шүүмжлэл дагуулдаг. Монголчуудыг дотор нь хоёр хувааж, нэг талаас жинхэнэ ардад (хүн амын дийлэнх олонх) бүх эрхийг эдлүүлж, нөгөө талаас ашгийг эрмэлзэн бусдыг зарж амьдрагчид, жинхэнэ худалдааны ба мөнгө хүүлэгчид, ван, гүн, хутагт хувилгаад, сүм хийдэд үргэлж суух санваартан, лам нарыг сонгох, сонгогдох эрхийг хассан төдийгүй цаашдаа энэ нь дараа дараагийн нугалаа, завхрал улс төрийн хэлмэгдүүлэлтэд хүргэсэн сургамжийг үлдээсэн билээ.

Бас нэгэн хатуу түүхэн сургамж бол Үндсэн хуулиа боловсруулах, батлах явцад аль болох гадны хүчний нөлөөг саармагжуулах явдал байсан билээ. 1920-оод оны дунд үеийн Монгол орны нөхцөлд Коминтерн, БХК(б) нам зэрэг гадны хүчний нөлөө хэтийдэж, 1921-

¹ Б.Чимид редакторын тодотгол, уншаад төрсөн бодол, хадгалж явдаг сэтгэл (Монгол Улсын Үндсэн хууль, баримт бичиг, Эмхэтгэж тайлбар бичсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан, Улаанбаатар, 2004, XXIV.дахь тал)

1924 оны зурвас үед жам ёсны голдиролдоо явж байсан үйл явцыг завхруулж, “ажилчин, тариачин” хэмээх хөдөлмөрийн ардын эрх ашгийг Монголын малчдын уламжлалт нийгэмд тулган хүлээлгэж, “жинхэнэ ард”-ын эрх ашгийг хамгаалах Үндсэн хуулийн үзэл баримтлалыг “нялзаасан” билээ.

Өмнөх тогтолцооны үед Үндсэн хуулийг социалист ба хөрөнгөтний Үндсэн хууль хэмээх хоёр хэв маягт ангилан үзэж, Анхдугаар Үндсэн хуулийг социалист эрх зүйн хэв маягт “шууд” багтаан үзэж иржээ.

Үндсэн хуулийн эрх зүйн салбарын нэрт эрдэмтэн Э.Авирмэд бичихдээ: Үндсэн хууль гэдэг нь латины тогтоох гэсэн үгнээс гарч, улмаар дэлхий нийтийн чанартай нэр томьёо болжээ. Анх эртний Римийн империйн хууль тогтоомжуудад энэ нэр томьёо хэрэглэгдэж байв. Эртний боол эзэмшлийн болон феодалын нийгмийн үед Үндсэн хууль гэдэг нэр томьёог хэрэглэхдээ улсын гол хууль гэсэн утгаар бус, харин Эзэн хааны зарлиг, төрийн байгууллагаас гаргасан хууль, бусад шийдвэр зэргийг тэгж нэрлэж байсан ажээ.

Хөрөнгөтний нийгэм үүсэж тогтохын хамт хөрөнгөтний Үндсэн хууль буй болж, тэр нь “улсын гол хууль” гэдэг утгатай нэр томьёо болсон байна. Хөрөнгөтний Үндсэн хууль бол капиталист нийгмийн үүсэж тогтох үед феодалын нийгмийн эдийн засгийн суурийг устгах, хөрөнгөтний нийгмийн улс төрийн байгуулалтыг бэхжүүлэхэд зохих роль гүйцэтгэжээ... Бүх Үндсэн хууль ангийнхаа агуулгаар хөрөнгөтний ба социалист гэдэг хоёр түүхэн маягт хуваагдана. Энэ нь нийгмийн капиталист, социалист хоёр систем оршин байгаагаар тайлбарлагдана”² хэмээн бичиж үлдээжээ.

Нэрт эрдэмтэн Б.Чимид Үндсэн хуулийн үзэл баримтлал, тогтоосон улс төрийн дэглэм, төр, нийгмийн харилцааны мөн чанарын үүднээс агуулгын чанартай шалгуураар ангилан үзэж Үндсэн хуулийн хэв маягийг тогтоох, үечлэх санал дэвшүүлжээ. Тэр бээр “Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал” өгүүлэлдээ “Монгол Улс социалист маягийн Үндсэн хуульд байгууллыг тогтоон хэрэгжүүлсэн үе 1921-1990 оныг хамаарна. Энэ үед 1924, 1940, 1960 оны гэсэн гурван Үндсэн хууль дамжин хөгжсөн бөгөөд хэдийгээр тоон ялгаатай, тодорхой онцлогтой ч мөн чанар, үзэл баримтлалын хувьд социалист Үндсэн хуульд хамаарах нэгэн хэв маягтай учир нэг ангилалд багтаан үзэж байна” гэжээ. Мөн тэр бээр цааш нь “1921 оны Үндсэн хууль Монгол Улсад Үндсэн хуульд байгууллыг анхлан тогтоосноор онцгой гавьяатай бөгөөд 16 жил үйлчилж, хувьсгалын

² Э.Авирмэд, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Төрийн эрх зүй, Уланбаатар, 1969, 33 дахь тал.

ардчилсан шатны зорилтыг хангасан гэж үздэг. Уг хуулиар улсын зорилгыг нийгэм журам ба эв хамт ёсонд нийцүүлэн явуулна гэж зааснаараа социалист чиг баримжаатай гэж буй юм” хэмээжээ.

Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтносон бүрэн эрхийг анх удаа Үндсэн хуулийн түвшинд заан бэхжүүлсэн нь Үндсэн хуулийн эрх зүйн гол институт, судлагдахуун болсон билээ. Монгол Улсынхаа тусгаар тогтнолыг Үндсэн хуулийн хэмжээнд тунхагласнаар түүнийгээ олон улсын “нүдний өмнө барьж” улс төр, эдийн засгийн бүрэн тусгаар байдлын төлөө тэмцэх хууль зүйн үндсийг тавьсан гэсэн Б.Чимид аругайн дүгнэлттэй санал нэг байна. Хэдийгээр эл зорилгод удтал бүрнээ хүрч чадаагүй ч дараа дараагийн Үндсэн хуульд залгамжлуулан дэлхийн II дайны дараа Дундад Иргэн Улс болон бусад зарим орноор хүлээн зөвшөөрүүлж, 1961 онд НҮБ-ийн гишүүн болсноор дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн, бүх оронд бүрэн эрхт тусгаар улс гэдгээ хүлээн зөвшөөрүүлж чадсан юм³.

1924 оны Үндсэн хуульд парламентын засаглал хэлбэрийн хувьд тусгагдсан ч агуулгын хувьд гүйцэд төлөвшлөө олоогүй гэж үздэг. Гэхдээ Бүгд найрамдах засаглалыг баталгаажуулсан анхдугаар Үндсэн хуулийн заалтууд нь 1992 оны шинэ Үндсэн хуулийн хөрс нь болж өгчээ.

1992 оны Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож мөн сонгож байгуулсан төрийн эрх барих байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” хэмээн Анхдугаар Үндсэн хуулийн үзэл санааг жинхэнэ агуулгаар нь тогтоож өгсөн байна.

Үндсэн хуулиар улс орны эдийн засаг, улс төр, нийгмийн байгууллын үндсийг заан бэхжүүлж өгсөн байдаг. Тэгвэл Анхдугаар Үндсэн хуульд тусгаар тогтнолын нэг баталгаа болсон эдийн засгийн бие даасан байх бодлогыг анхлан бэхжүүлж өгснөөрөө том дэвшил болсон гэж хэлж болно. Тодруулж хэлбэл, улсын эдийн засгийн суурь, улсын төсвийн орлого, зарлагын тогтолцоог анх удаа тодорхойлж өгсөн байна.

Анхдугаар Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “газар ба уурхай хийгээд ой мод, ус, тэдгээрийн баялгууд ... ард түмний мэдэлд байх” Хоёрдугаар бүлгийн 5 дугаар зүйлийн улсын дээд эрх барих газруудын эрхлэн шийтгэвэл зохих зүйлүүдийг тодорхойлсон улсын санхүү-зээл, гадаад, холбоо, цэргийн байгуулалт, мал аж ахуй, хүн, мал эмнэлгийг хөгжүүлэх талаар тавих зорилт, авах

³ Б.Чимид, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн тулгамдсан зарим асуудал, Хууль дээдлэх ёс., 2011., №4 (35). 8 дахь тал.

арга хэмжээний тухай заалтууд шинэ эдийн засаг, аж ахуй соёлын үндсийг бүрэлдүүлэх чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хууль эрх зүйн эх үндэс болж үйлчилснийг И.Дашням абугай тэмдэглэсэн байна.⁴

Анхдугаар Үндсэн хуулиар өмчийн олон хэлбэр оршин байхыг үгүйсгээгүй. Харин гадаад худалдааны онц эрхийг төр эдлэх заалт 1920-иод оны манай улсын нөхцөл байдлын хувьд том дэвшил байлаа. Үндсэн хуульг жам ёсны хөгжлийн үүднээс шинжлэн үзвэл төрийн дээд институт бүрийн бүрэн эрхийг Үндсэн хуулиар хязгаарлах, харилцан хяналттай, хариуцлага тооцох механизмтай тогтоож өгснөөр дарангуйлал, хүчирхийлэл гарахгүй байх хууль зүйн баталгаа бүрдэх ёстой байв. Энэ тухайд академич Ж.Болдбаатар тэмдэглэхдээ “... 1924, 1940, 1960 оны Үндсэн хууль үйлчлэх үед төрийн эрх мэдэл хуваарилах үзэл баримтлал сонгодог утгаараа үйлчилж чадаагүй нь нь улс төржсөн нэг намын ноёрхол, шүүх эрх мэдлийн бие даасан байдал хязгаарлагдмал, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хүчин чадал, механизм сул байснаар тодорхойлогдоно”⁵ хэмээн үзсэнтэй үндсэндээ санал нийлж байна.

“Монголын нийгмийг “зөвлөлтчилөх” тусам хувийн өмч рүү халдан довтлох болов” гэж Ж.Болдбаатар абугай тэмдэглэжээ. 1930-1932 онд феодал, тайж угсаатай хүмүүсийн хөрөнгийг хураажээ. Олон үе дамжин, нойр хоолгүй, өөрсдөөсөө ч харамлан зүтгэж байж хураасан чинээлэг айл өрхийн хөрөнгөд халдана гэдэг нь хувийн өмч рүү бүдүүлгээр довтолж, хүний эдийн засгийн эрх, эрх чөлөөний зарчмыг дээд зэргээр ноцтой зөрчсөн үйлдэл байв. Харин энэ байдал 1950-иад оны эцэст ардын хувийн аж ахуйтныг хоршоолох үед арай аядуу байдлаар давтагдсан юм. Ийнхүү Монгол улсын эдийн засгийн үндсэн нь эхлээд хувийн, дараа нь нийгмийн өмч байж, өнгөрсөн зууны эцсээр эргээд өмчийн олон хэлбэр, ялангуяа хувийн өмч зонхилох болов ... 1990 он хүртэл хувийн өмчийг үл зөвшөөрч, зах зээлийн механизмыг үндсэндээ үгүйсгэсэн төвлөрсөн төлөвлөгөөнд хатуу баригдаж байсан нь манай улсын эдийн засгийн хөгжилд гол саад бэрхшээл болж байв. 1990-ээд оноос чөлөөт зах зээлд шилжиж, эдийн засгийн хөгжил жам ёсны голдиролдоо орсон билээ.

Тус улсын эдийн засгийн гол салбар болох мал аж ахуйг эрхлэх арга ухаан технологи, соёлд ихээхэн өөрчлөлт гарсан хэдий боловч, бэлчээрийн сонгодог мал аж ахуйн уламжлалт хэлбэрийг дэлхий дахинд төрхөөр нь авч үлдсэн хуруу дарам цөөн тооны орнуудын нэг

⁴ И.Дашням, Монгол оронд феодалын эрх зүйг халж, шинэ эрх зүй бүрэлдэн тогтносон нь (1921-1940), Улаанбаатар, 1993, 133 дахь тал

⁵ Ж.Болдбаатар, Монголын төр, шашин, соёлын түүхийн судалгаа, Улаанбаатар, 2018, 91 дэх тал

болж байна.

Үндсэн хуулийн эрх зүйн нэг гол институт бол төрийн байгуулал тодруулбал, төрийн байгууллагын тогтолцоо, зарчим, бүрэн эрх юм. Монгол Улсын Анхдугаар Үндсэн хуульд төрийн байгууллагуудын шинэ тогтолцоог бэхжүүлсэн. Үүнд Улсын Их Хурал, Улсын Бага Хурал, Улсын Бага хурлын Тэргүүлэгчид, Засгийн газар, яамд гэсэн төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг тогтоож өгчээ.

Анхдугаар Үндсэн хуулиар төрийн дээд эрх мэдлийг дараах хэдэн байгууллагад хуваарилсан нь онцлог зохицуулалт болсон. Анхдугаар Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэг нь “Улсын дээд эрхийг барих газрын тухай” гэсэн бүлэг бөгөөд тус бүлгийн 4 дүгээр зүйлд “БНМАУ-ын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах бөгөөд мөн хурлын чөлөө цагт Улсын Бага Хуралд хадгалуулах ба бас мөн хурлын чөлөө цагт Бага хурлын тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино” гэж заасан нь улс орны хөгжлийн тухайн цаг үед төлөөллийн байгууллагын зэрэгцээ гүйцэтгэх, засаглалын зүгээс гүйцэтгэн захирамжлах удирдлагаар хангах шаардлага бодитой оршиж байсантай холбоотой гэж тайлбарладаг. Үндсэн хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Бага хурлын чөлөө цагт улсын дээд эрхийг Бага хурлын тэргүүлэгчдэд хадгална гэснийг Бага хурлын тэргүүлэгчид ба засгийн газрын дунд хадгална гэж төлөөлөгчдийн саналаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Төрийн эрх мэдэл хуваарилах сонгодог онол, зарчмын үүднээс авч үзвэл эрх мэдэл холилдсон, харилцан хяналт тэнцэлтэйгээр эрх мэдэл бүрийг нарийн тогтоож өгч чадаагүй бөгөөд энэ нь 1930-аад оны дунд үеэс хойш илтэд тодорч нэг хүн, нэг байгууллагад эрх мэдэл хэт төвлөрөх нөхцөлийг бий болгосон үр дагаврыг бий болгожээ.

Хүний эрх, эрх чөлөө буюу иргэдийн үндсэн эрх, эрх чөлөө үүргийг заан бэхжүүлсэн хэм хэмжээнүүд Үндсэн хуулийн эрх зүйн гол институт байдаг. Тэгвэл Анхдугаар Үндсэн хуульд заан бэхжүүлсэн иргэдийн эрх, эрх чөлөөний талаарх заалтууд тухайн цаг үедээ үнэхээр шинэ содон зүйл байв. Энэ талаар академич Ж.Болдбаатар аругай бичихдээ “Тус улсын Анхдугаар Үндсэн хуулиар анх удаа Монгол хүний эрх, эрх чөлөөг тунхагласан нь хүний наад захын эрхийг үл мэдрэн, хамжлагат ёсны бурангуй байдалд байсан монголчуудын хувьд цоо шинэ зүйл, хувь хүний халдашгүй дархан байдлыг тодорхой хэмжээгээр эдэлсэн түүхэн том үйл явдал байлаа. Монгол хүн сонгох, сонгогдох, үг хэлэх, хурал цуглаан хийх, хэвлэн нийтлэх эрхээ эдэлж, улс амьдрал руу тэмүүлж байлаа. Ялангуяа эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийн нэгэн адил тэгш эрх олгосноор Монгол

Улс өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудаас өмнө эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хуульчлан тунхагласан нь Монголын төдийгүй, олон улсын эрх зүйд гарсан шинэ үзэгдэл байв” хэмээн тэмдэглэжээ.

Анхдугаар Үндсэн хуульд тунхагласан хүний эрх, эрх чөлөөний түүхэн дэвшилттэй болон саар зүйлийн талаарх асуудлыг эрдэмтэд аль аль талаас нь авч үзэж дүгнэсэн байна. Б.Чимид багш бичихдээ “...Төрийн байгууллагын нийгэмшлийн үндсийг большевик маягаар сонгож пролетари буюу эсвэл “ажилчин, тариачин” хэмээсний оронд “жинхэнэ ард” гэж хүн амын асар олонхын хамгийн ядуулаг хэсгийг засгийн эрхийн эх үүсвэр болгосон байна. Ингэснээр монголын ард түмнийг улс төрийн хагаралд оруулж нэг хэсэг нь нөгөө хэсгийгээ ангийн хувьд “устгах” эсэх зүүний үзэл баримтлалд автан улаан хувьсгалчийн хэлмэгдүүлэлд хүргэсэн гэх үндэстэй” гэжээ.

Анхдугаар Үндсэн хуулийн 1 дүгээр бүлэг нь Монголын жинхэнэ ардын эрх чөлөөг илтгэн тунхаглах нь гэсэн нэртэй бөгөөд сонгох, сонгогдох эрхийн 4 дүгээр бүлгийн 35 дугаар зүйлд ”Аливаа хурлын төлөөлөгчдийг сонгох ба мөн төлөөлөгчдөд сонгогдох эрхгүй хүмүүс нь:

Нэг. Ямагт ашгийг эрмэлзэж бусдыг зарж мөлжин амьдрагчид;

Хоёр. Ямагт бусдыг хөлслөн зарах ба хөрөнгө орлого зэргийн үржлээр амьдарч, жинхэнэ худалдааны ба мөнгө хүүлэгчид;

Гурав. Урдын ван, гүн ба хутагт хувилгаад, жич орон хийдэд үргэлж суух санваартан лам нар;

Дөрөв. Солиорсон ба ухаан эвдэрсэн бөгөөд зохих газраас шинжлэн батлагдагсад;

Тав. Эд хичээх зэргээр нэрийг гутаах явдал үйлдэж, зарга, шүүх газраас ял шийтгэгдэгсэд болно.

Ийнхүү эхний гурван хэсгийн сонгож, сонгогдох эрх буюу улс төрийн эрхийг хассан байна. Энэ нь цаашдаа иргэдийнхээ нэг хэсгийг хэлмэгдүүлэх хууль зүйн үндэслэл болж өгчээ.

Анхдугаар Үндсэн хуулийн 31-33 дугаар зүйлүүдэд “Нутгийн хурал нь аливаа аж ахуй ба албаны хэргүүдийг гүйцэтгэн явуулахаар өөрсдийн дундаас аймаг, хошуу, сум, баг, арван гэрийн аливаа хэрэг явдлыг гүйцэтгэж захиргааны газрыг сонгон байгуулбал зохих бөгөөд мөн албан хаагчдыг нэгэн жилийн хугацаагаар сонговол зохино. Дээр дурдсан аливаа захиргааны газрууд тус тусын орон нутгийн хуралд хянан байцаагдвал зохино. Аймаг, хошуу, сум, баг, арван гэрийн хурал ба захиргааны газруудын эрх хэмжээ харилцах зэрэг явдлыг нутгийн захиргааны дүрэмд заасан ёсоор гүйцэтгэн явуулбал зохино хэмээн тус тус заажээ.

“Засаг захиргааны нэгж нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс хуваарилагдсан газар нутагтай, харьяалагдах иргэдтэй, төрийн үйлчилгээг хүргэж удирддаг засаг захиргааны байгууллагатай төрийн байгууламжийн үндсэн элемент мөн”. Нутаг дэвсгэрийг засаг захиргааны хэдэн түвшинд хуваах нь улсын нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарна.

Улс орнуудад засаг захиргааны нэгжүүдээ төр ёсны уламжлалаа даган шатлал бүрээр нь муж, тойрог, гацаа, тосгон ... зэргээр нэрлэсэн байдаг. Монголын төр ёсны хөгжлийн түүхээс үзэхэд Монгол нутаг дээр тогтож байсан монгол угсаатан улсууд цөм төрийн байгууламжийн хувьд нэгдмэл төвлөрсөн хэлбэрийн улсууд байсан бөгөөд Хүннүгээс эхлэн улсаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваариар баруун, зүүн гар, төв хэсэг гэж гурав хуваан захирч байжээ. Энэ нь түүний дараагаар залгамжлан гарч ирсэн Сүмбэ (МЭ I-III зуунд), Нирун (330-555) зэрэг улсуудад уламжлагдан улмаар 1206 онд Их Монгол Улс байгуулагдахад эзэн Чингис Хаан улсаа мөн л баруун, зүүн төвийн итгэлт нөхдөөрөө толгойлуулан нэгтгэн захирсан билээ. Манай улсын засаг захиргааны зарим нэршил Хүннүгээс зарим нь Их Монгол Улсаас эх авсан байдаг.

Баг, аймаг гэсэн засаг захиргааны нэгж Хүннүгээс улбаатай гэдгийн үндэс нь Монголын төрт ёсны нэг тулгар зарчим болох аравтын тогтолцоо нь Хүннүгийн үеэс эхлэлтэй байсанд оршино. Энэ тогтолцоо нь ялангуяа нүүдэлчдийг зохион байгуулахад тун тохиромжтой аймгийн цэрэг захиргааны зохион байгуулалт байжээ. Хүннү, Сүмбэ, Нирун, Жужан, Түрэг, Уйгар, Киданы аль ч аравтын тогтолцоо нь захиргаа аж ахуйн нэгдмэл цогцолборыг бий болгож цаг алдалгүй маневрлах, тодорхой зүйлд хүч анхаарлыг төвлөрүүлэх, нэгдмэл удирдлага зохион байгуулалтаар хангах нөхцөл боломжийг өгч байснаараа нүүдэлчдийн төрийн оршин амьдрах чадварын нэг гол хүчин зүйл болсон байна.

Цэргийн нэгдсэн аравтын зохион байгуулалт нь улсын баруун, зүүн гар, төвийн хэсгийн бие даасан улсууд болж салан тусгаарлах бодлого баримтлах оролдлогыг хаахад чиглэсэн бөгөөд тэгснээрээ улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын эрх ашигт тохирч байв.

Их Монгол Улсын мянгатын тогтолцоо нь өвөг дээдсийнхээ төрийн энэхүү уламжлалыг бүтээлчээр өвлөсөн баримт бөгөөд Монголын эзэнт гүрний түвшинд хүргэхэд чухал нөхцөл нь болж өгсөн билээ. Монгол төрийн аравтын тогтолцоо нь олон зууны шалгарал сорилтыг даван туулж 1923 онд баталсан нутгийн захиргааны дүрмээр хуульчлан бэхжүүлсэн бөгөөд (аймаг, хошуу, сум, баг, арван гэр) нь Анхдугаар Үндсэн хуульд шингэсэн билээ. Энэ санаа Монгол Улсын

шинэ Үндсэн хуульд тусгалаа олсон. Харин шинэ Үндсэн хууль (Их Цааз)-ын төслийг хэлэлцэх явцад хошуу гэсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хасагджээ. Ингэхлээр Анхдугаар Үндсэн хуулиар тогтоосон Засаг захиргааны нэгжүүд Монголын төр ёсны хөгжлийн зүй ёсны үргэлжлэл болсон нь харагдаж байна.

Нутгийн удирдлагын тогтолцоог тодорхойлохдоо олон дэвшилтэт санааг шингээжээ. Тухайлбал, Аймаг, хошуу, сум, баг, арван гэрийн хурал нь нутгийн өөрөө удирдах ёсны үр хөврөл байсан гэж үзэж байна. Хурлуудын эрх хэмжээ, сонгох журам төлөөлөгчдөд тавих шаардлага зэрэг нь Нутгийн өөрөө удирдлагын зарим элементүүдийг агуулжээ. Эдгээр хурлууд 1992 он хүртэл төрийн эрх барих орон нутгийн байгууллагын эх үндэс болсон байв. Монгол Улсын нутгийн захиргааны дүрмийн 1 дүгээр зүйлд “... арван гэрээс дээш баг, сум, хошуу, аймаг улсын Засгийн газар хүртэл тус тусын ардын төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалсан хурал байгуулан элдэв хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцүүлж, олонхын саналаар таслан тогтоож, ардын эрхийг эрхэмлэн хүндэтгэвэл зохино гэж заасан нь орон нутгийн эрх барих төлөөлөгчдийн байгууллага болохыг бэхжүүлсэн хэрэг юм.

Анхдугаар Үндсэн хуулиар төрийн захиргааны байгууллагууд нь тус тусын орон нутгийн хурлын хяналтын дор ажиллах ажлаа тайлагнаж байхыг заасан нь орон нутгийн эрх барих байгууллага болохыг харуулж байна.

Засаг захиргааны нэгжийн дарга, хурлын төлөөлөгчдийг сонгох шалгуур, шаардлагыг нутгийн захиргааны дүрэмд зааснаар “Улсын ба аймаг, хошуу, сум, баг, арван гэрийн даргад хүртэл аливаа албан тушаалтан буюу тус бүрийн хурлын төлөөлөгчдийг сонгоход цөм эрх биш ард олны зовлон зүдгүүрийг нэвтэрхий мэдэх, олны тусыг бодох бөгөөд цэвэр шударга, чадвал бичиг үсэгт боловсронгуй, өөр өөрийн оролдсон явдлыг магадаар бүтээн чадах хүнийг сонговол зохино. Гагцхүү арван гэрийн даргад бичиг үсэгт боловсроогүй боловч зөв шударга хүн бол сонгож болно” хэмээсэн энэхүү заалт өнөө цагт Иргэдийн хурлын төлөөлөгчдөөс эхлээд Улсын Их Хурлын гишүүн, төрийн бүх шатны албан хаагчдад тавигдаж буй шаардлагыг агуулж байгаа учраас холбогдох хуулиудад баримтлал, зарчим түүхэн өв болох ач холбогдолтой юм.

Дүрмийн дараагийн зүйлд нь “Урдах зүйлд дурдсан бүхий л тушаалтан ба төлөөлөгчдийг сонгоход харьяат хурлын гишүүд дэмий ноёд, баяд ба ураг төрлийн нүүрчлэх ба эзэрхэг харгисын сүрээс айх ба эд ашигт шунах зэргээр зусарч, бялдууч, ховдог, авлигач, хааш яаш хүнийг сонгох зэргийн гэм өдүүлэх аваас сонгосон, сонгогдсон

хоёр этгээдийг цөм улсын цаазыг зоримгоор зөрчсөнд үзэж хууль ёсоор хүндэд яллан уул тушаалын орыг өөр сонгуулна гэж заасан нь төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхтай холбоотой хууль тогтоомжийг батлан мөрдөхөд түүхэн эх сурвалжийн ач холбогдолтой заалт юм.

Төрийн бэлгэдлийг заан бэхжүүлсэн хэм хэмжээнүүд нь Үндсэн хуулийн эрх зүйн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл болдог нэгэн илэрхийлэл нь болдог.

Монголын төр ёсны уламжлал шинэчлэлийн хүрээнд зуун, зуун жилээр үе дамжин уламжлагдан баяжиж ирсэн төрийн бэлгэдэл Монгол Улсын шинэ Үндсэн хуульд тусгалаа олж Их цагаан туг, төрийн сүлд, далбаа, төрийн тамга, дуулал гэсэн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдлийг тодорхойлон засаж өөрчлөх саар зүйлүүдийг хамтад нь авч үзэж, авах гээхийн ухаанаар хандахад хүргэсэн болой. Төрийн сүлд нь улсын албан ёсны таних тэмдэг, тусгаар тогтнолын бэлгэдэг юм. Монголын төрт ёсны түүхэнд төрийн сүлдний уламжлал бий. Үүнд: шонхор шувуу, соёмбо үсэг, их цагаан туг гурав Монголын сүлд тусгаар тогтнолын бэлгэдэл болж байсан тухай мэдээ баримт сурвалж бичгүүдэд тэмдэглэн үлдсэн байдаг. Энэ уламжлал ч Анхдугаар Үндсэн хуульд тусгалаа олжээ.

Тэгвэл XVII зуунаас “Соёмбот далбааг тусгаар тогтнолын бэлгэдэл” болгож байсан уламжлалын дагуу 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын дараагаар тусгаар тогтнолоо дахин сэргээсний олноо өргөгдсөн Монгол Улсын төрийн бэлгэдэл болгосон байна. Энэ уламжлал Анхдугаар Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлд “Улсын сүлд тэмдэгт дээр дурдсан соёмбо үсэг, түүний доод этгээдэд бадамлянхуа цэцгийн зураг бүхий сүлд тэмдэг хэрэглэн явуулбал зохино” гэж зааснаар үргэлжилжээ. Дараагийнх нь дөчин есдүгээр зүйлд “Улсын туг далбааг улаан өнгөтэй бөгөөд дунд нь улсын сүлд тэмдгийг оруулан үйлдүүлж гүйцэтгүүлбэл зохино” гэж заасан байна.

Анхдугаар Үндсэн хуульд төрийн тамгыг тодорхойлон заасан байна. Үүнд “Улсын Их Хурлаас дараалан Засгийн газар, олон явдлын яам, албаны газруудын тамгыг цөм дөрвөлжин бөгөөд нүүрийн дундад соёмбо гэдэг эрхэм үсэг, түүний хоёр этгээдэд уул газрын нэр сэлтийг үйлдүүлэн гүйцэтгүүлбэл зохино” гэжээ.

Төрийн бэлгэдлийн нэг төрийн тамга Хүннүгээс эхтэй байна. Хүннүгийн Шаньюй төрийн бүрэн эрхт эзний бэлгэ болсон төрийн хаш тамгатай байв. Их Монгол Улсын хаад хасбуу тамга хэрэглэж байв. Олноо өргөгдсөн Монгол Улсын төрийн тамгыг зарлигаар

тогтоосон хууль зүйлийн бичигт заахдаа Богд хаанд хаш эрдэнэ тамга нэг, түүнчлэн албан тамга, мөнгөн тамга хэрэглүүлэх болгожээ.

III. Дүгнэлт

Анхдугаар Үндсэн хуулиар бэхжүүлэн заасан төрийн байгуулал, иргэний эрх, эрх чөлөө, нутгийн захиргаа гээд гол институтүүдэд хийсэн судалгаанаас харахад гаднаас үлгэр загвар авч “хуулбарласан” хэмээн шүүмжлэгддэг ч төр ёсны түүхэн уламжлалдаа сайтар тулгуурласан нь илт байдаг. Түүнчлэн Монголын эх орончид, үндэсний ардчилсан үзэлтнүүд Монгол орныхоо хөгжлийг жам ёсны голдиролоор нь хөтлөн залах гэж их ч мэрийж хичээсэн, гадныхан өөрсдийнхөө туршиж буй зам мөрөөр явуулах гэж түүнээс ч дутуугүй шахаж дарамталсан нь харагддаг.

Монголын ардчилсан үзэлтнүүд тэдний саналд “авах гээхийн ухаанаар” хандаж, Коминтерноос зайлшгүй тулгасан зарим зүйлийг хэлбэр төдий авч, Үндсэн хуулийн гол агуулгыг хэвээр хадгалан Улсын Их Хурал- Улсын Бага Хурал-АЗГ гэсэн гурван субъекттэй Монгол тогтолцоог хатуу баримталжээ.

Тусгаар тогтнолоо сэргээж, бүрэн эрхт улс болох гэсэн туйлын мөрөөдлөө хэрэгжүүлэхийн тулд колони ба бусдын хараат байдлаас гарч, эрх чөлөөгөө олж авсан олон улс орны сонгосон зам болох, нийгэм журмыг баримжаалсан, ардын ардчилсан хэлбэрийг сонгожээ. Ардчиллын энэ хэлбэр тухайн үед Монголын ард түмний олонход чихэнд нь чимэгтэй, ойр дөт санагддаг байсан нь ойлгомжтой.

1921-1924 оныг хүртэлх түүхэн зурвас үед сонгож авсан хөгжлийн зам, төрийн тогтолцоо, хүний эрхийн байдал төлөвийг эдүгээчлэх боломжгүй юм.

Хэмжээгүй эрхт хаант засгаас хэмжээт цаазат хаант засаглалд шилжсэн нь үнэхээр улс төрийн түүхэн дэвшилтэт үйл явдал байлаа.

Монгол Улс түүхэндээ анх удаа бичмэл Үндсэн хуультай болсон нь тусгаар тогтнолын баталгаа, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх үндсийг бүрдүүлсэн юм.

[Ном зүй]

- Э.Авирмэд, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Төрийн эрх зүй, Улаанбаатар, 1969
- Ц.Батбаяр, Амар сайд, Сэцэн хан нар 1925 онд Хятадад зорчсон нь, Улаанбаатар, 2015
- Ц.Батбаяр, Д. Лүндээжанцан, Хэмжээт цаазатаас бүгд найрамдах засагт шилжсэн нь: Анхдугаар Үндсэн хууль (1921-1924), Улаанбаатар, 2023
- Р.Болд, Бүрэн эрхээ хязгаарлуулсан тусгаар тогтнол (1921-1925), Улаанбаатар, 2021
- Монголын төр, шашин, соёлын түүхийн судалгаа, Улаанбаатар, 2018
- Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан, Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, Улаанбаатар, 2021
- И.Дашням, Монгол оронд феодалын эрх зүйг халж, шинэ эрх зүй бүрэлдэн тогтносон нь (1921-1940), Улаанбаатар, 1993
- С. Жалан-Аажав, Ардын хувьсгалт төрийн хууль тогтоох үйл ажиллагааны үндсэн чиглэл (1921-1940), Улаанбаатар, 1967
- Д.Сангиданзан, Хувьсгалын ардчилсан шатан дахь ардын төрийн үндсэн үүргүүд (1921-1940), Улаанбаатар, 1974
- М.Санждорж, Ардын төрийн түүх, Улаанбаатар, 1974
- Д. Лүндээжанцан, Ч.Энхбаатар, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, Улаанбаатар, 1996
- Д.Лүндээжанцан, Аюулгүй байдал, хөгжил, төр, эрх зүй, Улаанбаатар, 2002
- Ч.Өнөрбаяр, А.Бямбажаргал, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, Улаанбаатар, 2019
- Ж.Цэвээн, Улсын эрх. Монгол бичгээс хөрвүүлсэн С.Идшинноров, С.Ичинноров, Улаанбаатар, 2014
- Б.Чимид, Редакторын тодотгол, уншаад төрсөн бодол, хадгалж явдаг сэтгэл (Монгол Улсын Үндсэн хууль, баримт бичиг. Эмхэтгэж тайлбар бичсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан, Улаанбаатар, 2004)
- Б.Чимид, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн тулгамдсан зарим асуудал, Хууль дээдлэх ёс, 2011, №4 (35)
- Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, Улаанбаатар, 2008
- БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл (1921-1940), Улаанбаатар, 1972
- W.E.Butler, The Mongolian Legal System, London, 1982
- Ch. Bawden, Modern History of Mongolia, Second edition, London, 1989.

[Abstract]

**Examination of Mongolia's First
Constitution (1924) from a Legal Perspective**

Lundeejantsan Danzan

*Doctor of Laws (Sc.D.), Professor
Chairman of Academic Council, Shihihutug University
Ulaanbaatar, Mongolia*

Batbayar Tsedendamba

*Academician, Doctor of History (Sc.D.)
Principal Researcher at the Institute of History
and Ethnology, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia*

The Constitution of Mongolia as the fundamental source of the country's statehood and constitutional order. Legal concepts and significance of the Constitution. The drafting and adoption of the first Constitution as a crucial historical event in Mongolia's development. The first Constitution confirmed Mongolia's sovereignty and independence. Comparison of legal provisions between the first Constitution, which defined the country's economy, politics, society, human rights, and freedoms, and the democratic Constitution of 1992. The Constitution's provisions regarding national defense and state symbols. The importance of these constitutional provisions and their significance.

[Keywords]

Constitution, Sovereignty, Economy, Politics, Social Foundations, State Structure, Citizens' Rights and Freedoms, Voting Rights.